

Радио Телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГ-ын 2025 оны 1,2 дугаар улирлын Хуулийн хэрэгжилтийн үр дагаварын тайлан

2025.05.13 Улаанбаатар хот Хөвсгөл аймгийн РТСГ-ын даргаар ажиллаж байгаад 2024.12.11-ний өдөр РТҮС УТҮГ-ын захирлын Б\195 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн Пунцагбалжирын нэхэмжлэлтэй иргэний хэрэгт хуулийн зөвлөх Б.Төрбат итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон ажиллаж байна.

Дээрх нэхэмжлэлтэй иргэний хурал нь Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн анхан шатны тойргийн шүүхэд 2025.03.12-ны өдөр товлогдсон байсан боловч нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн шүүх хурал давхацсан гэсэн шалтгаанаар хойшилсон. 2025.04.16-нд хуралдан улмаар нэхэмжлэгч, хариуцагч талуудаас нэмэлт тайлбар, нотлох баримт гаргуулан авч, 2025.05.07-нд хуралдан хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 41-р зүйлийн 41.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн РТСГ-ын нэр бүхий ажилчидаас гэрчийн мэдүүлэг гаргуулан авахаар болж Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхээр даалгавар гүйцэтгүүлэхээр шүүгчийн захирамж гарч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн болно.

РТҮС Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын тушаалаар хуулийн зөвлөх Б.Төрбат нь Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажилладаг бөгөөд тайлангийн хугацаанд 2 удаагийн хуралд оролцон ажилласан болно. Мөн захирлын тушаалаар Эрчим хүчний зохистой хэрэглээг зохицуулах үүрэг бүхий ажлын хэсэгт гишүүнээр томилогдон 2025.05.07-ны өдөр анхны хурлаа хийж зохих шийдвэрийг гаргасан байна. Хуулийн зөвлөх Б.Төрбат нь тайлангийн хугацаанд РТҮС Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын тушаал шийдвэрийн болон бусад байгууллага хувь хүмүүстэй байгуулсан гэрээнүүдийн боловсруулалт, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.